| НИЙТ ДҮН |                                |                                   | 115150 г буюу 115.15 кг  |                         |      |

### Химийн бодисын агуулах

Лабораториудад ашигладаг химийн бодисуудыг ШМЭХүрээлэнгийн В1 давхарт байрлах 12 м<sup>2</sup> хэмжээтэй өрөөнд байрлуулдаг бөгөөд, уг өрөө нь механик агааржуулалтын системтэй, шал хана нь химийн бодис шингээгдэхгүй материалаар хийгдсэн, тавцан тавиуртай, дотор тал нь зохиомол гэрэлтүүлэгтэй байна.



Хүснэгт 6. Химийн бодис хадгалах агуулхын харагдах байдал

### **Химийн бодис ашиглалт**

Химийн бодисыг зөвхөн сургалт, туршилтын зориулалтаар ашигладаг бөгөөд сургалт явуулж буй сургалтын лабораториуд нь хөдөлмөр хамгааллын нөхцөл аюулгүй ажиллагааг бүрэн хангасан. Химийн бодистой харьцдаг багш, лаборантууд, оюутан, сурагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг сайтар танилцуулж гарын үсэг зуруулсны дараа сорил туршилтын хичээлийг эхлүүлдэг байна. Хэрэв зааварчилгаа аваагүй бол оюутан тухай туршилтын хичээлд оруулдаггүй байна.

### **Химийн бодисын тээвэрлэлт**

Химийн бодисыг худалдан авахдаа бага хэмжээгээр жилд 2 удаа авдаг бөгөөд намрын улирлын хичээлийн хэрэглэгдэхүүн бодис урвалжийг хавар захиалан 8 сарын сүүлээр хүлээн авч, хаврын улирлын бодис урвалжийг намар захиалан 1 дүгээр сард хүлээн авч сургалтанд ашиглаж байна. Шаардлагатай химийн бодис урвалж, хэрэглэгдэхүүн, багаж тоног төхөөрөмжийг худалдан авахдаа сургууль тус бүр химийн бодис урвалж худалдан борлуулах мэргэжлийн газар болох “Грийн Химистри ХХК”-тай хийгдсэн гэрээний дагуу хүргэлтээр хүлээн авдаг.

## ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН АГААРЫН ЧАНАР


Улаанбаатар хот нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай, Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг баруун өмнөд шувтрага үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг, далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн  $47^{\circ}55'$ , зүүн уртрагийн  $106^{\circ}55'$  –ын солбилцолд оршдог.

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь  $-49^{\circ}\text{C}$  хүрдэг, үнэмлэхүй их температур нь  $38.6^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их бага температурын агууриг нь  $87.6^{\circ}\text{C}$  болдог энэ эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй байна. Жилийн дундаж температур нь  $-3^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 1-р сарын температур нь  $-26^{\circ}\text{C}$  байх бөгөөд  $-30^{\circ}\text{C}$ -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.

Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ны орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур  $0^{\circ}\text{C}$ -аас доош буухгүй. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь  $17^{\circ}\text{C}$ , хамгийн халуун болсон нь  $38^{\circ}\text{C}$  хүрсэн. Зундаа  $30^{\circ}\text{C}$ -аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг. Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг хөх тэнгэрт хотуудын нэг бөгөөд жилдээ 250-иад хоног цэлмэг байдаг. Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй. Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай хахир өвөлтэй нутагт багтана. Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.


### ***Агаарын температур***

Улаанбаатар хотын агаарын температурын олон жилийн дундаж нь  $-0.5^{\circ}\text{C}$  байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдахыг харуулна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур  $-21.6^{\circ}\text{C}$  байдаг байна. Хавар  $0^{\circ}\text{C}$ -ыг давж дулаарах хугацаа 5 дугаар сарын сүүлчийн арав хоногт тохиолдох ба дунджаар 7-р сард хамгийн дулаан ба агаарын дундаж температур  $18^{\circ}\text{C}$  байна. Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэл дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна. Агаарын температурын жилийн дундаж үзүүлэлт 1966 оноос 2019 оныг хүртэл тасралтгүй нэмэгдэх хандлагатай өөрчлөгдсөн буюу 54 жилд 2.86 градусаар нэмэгдээд байна.



Зураг 7. Агаарын дундаж температурын өөрчлөлт /сараар, жилээр/

Улаанбаатар хот орчимд 2020 оны 1-р сарын байдлаар агаарын дундаж температур -17.4-22.0 градус хүйтэн, өдөртөө 3.2-9.7 градус, бусад хугацаанд -10.2-18.5 градус хүйтэн, шөнөдөө Буянт-Ухаа орчмоор -25.1-33.9 градус, бусад дүүргээр -17.5-30.0 градус хүйтэн байдаг байна.



Зураг8. Улаанбаатар хотын уур амьсгалын нөхцөл, 2020 оны 1-р сарын байдлаар

**Хур тунадас:** Улаанбаатар хот нь газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58.6% байгаа нь чийглэгдүү бүсэд багтахыг харуулна. Жилийн нийлбэр тунадасны хэмжээ Улаанбаатар хотод олон жилийн дунджаар 263.2 мм байсан гэж тооцоологдсон хур тунадас харьцангуй их унадаг нутагт хамрагддаг болохыг харуулж байна. Өвлийн улиралд (1-3 дугаар сард) дунджаар 17.1 мм тунадас унадаг. Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 6 дугаар сард огцом ихэсж, 7 ба 8 дугаар сард хамгийн их тунадас (86.9 мм) унадаг. Дулааны улиралд 210.6 мм хур тунадас ордог нь жилийн нийлбэр тунадасны 80 хувь, үүнээс 7-8-р сард 64.2 хувь нь унана. Намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багасаж, 11 дүгээр сараас өвлийн горимондоо шилжинэ. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Улаанбаатар хотод 1966-2019 оны хур тунадасны мэдээнээс үзэхэд хур тунадасны хэмжээ 166.2-395.6 мм-ийн хооронд

“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл

хэлбэлзсэн ба 1966-1981, 1994-2007 онд буурч цаашид завсрын онуудад өсөх хандлагатай өөрчлөгдсөн байна. Ерөнхийдөө 54 жилийн туршид 10 мм-ээр өссөн байна.

Харин 2020 оны ЦУОШГ мэдээнээс үзэхэд бүх дүүргээр хур тунадас багатай, 2-6 өдөрт нийт 0.0-0.3 мм тунадастай, 4 см зузаан цасан бүрхүүл тогтсон байна.



Зураг 9. Улаанбаатар хотын хур тунадасны өөрчлөлт, 1966-2019

**Салхины горим:** Улаанбаатар хотын салхины хурд олон жилийн дунджаар 2.4 м/с байдаг нь цаг агаар тогтуун бус бүс нутаг юм. Уг бүс нутагт тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцоо нөлөөлж, уулс хоорондын болон голын хөндийн баруун өмнөд, баруун хойд зүгийн салхи зонхилж ажиглагдана. Жилийн туршид хүчтэй салхи салхилах тохиолдол бусад газруудтай харьцуулахад 6-р сард хүчтэй салхи ажиглагдах боловч хүчтэй салхитай өдрийн тоо маш цөөн байдаг байна.



Зураг 10. Салхины дундаж болон хамгийн их хурдны жилийн явц

Салхины хурдны жилийн явцыг үзэхэд салхи нэлээн тогтуун байх ба хавар, зуны улиралд намар, өвлийн улирлаас 0.5 м/с-ээр их хурдтай салхилдаг байна. Харин тохиолдох хүчтэй (15 м/с-ээс их) салхитай өдрийн тоо 2 хоног тохиолддог байна. Хавар, зуны улиралд салхины хамгийн их хурд 25-28 м/с хүрч ажиглагддаг байна. Салхины дундаж хурд 0.6-1.6 м/сек, ихэнх хугацаанд салхи багатай тогтуун байдаг байна.

Агаарын чанар гэдэг нь стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанар юм. Хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан эсвэл физик, химийн урвалын дүнд шинээр бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг агаарын бохирдолтой гэж үздэг байна. Хэдийгээр агаарын бохирдол нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бохирдуулагч бодисуудын нийлмэл боловч шаталтаас үүдэлтэй агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг ихэвчлэн PM2.5 болон PM10 тоосонцруудын агууламжаар тодорхойлдог байна.




Зураг 11. Улаанбаатар хотын агаарын чанарын харуулууд



Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, авто зам, орон сууцны хороолол, үйлдвэрийн орчмын 15 цэгт автомат багаж болон химийн аргаар агаар бохирдуулах дараах бодисуудын агууламжийг тодорхойлж байна.

### Улаанбаатар хотын агаарын чанарын 7 хоногийн мэдээ /2025 оны 09-р сарын 01-07-ны өдөр/

Улаанбаатар хотын агаарт түгээмэл бохирдуулах бодис хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/, азотын давхар исэл /NO<sub>2</sub>/, тоосонцор /PM10, PM2.5/, нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/, озон /O<sub>3</sub>/-ны агууламжийг тодорхойлсон байна.



“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл



Улаанбаатар хотын 7 хоногийн агаарын чанар  
/2024 оны мөн үеийнхтэй харьцуулсанаар/

| № | Бохирдуулах бодисын нэр               | MNS 4585:2025 | 7 хоногийн дундаж агууламж, мкг/м³ |            | 24 цагийн дундаж хамгийн их агууламж, мкг/м³ |             | Стандартаас давсан тохиолдлын тоо, хувиар |         | Стандартаас давсан хамгийн их агууламж илэрсэн агаарын чанарын хяналт шинжилгээний автомат харуул |
|---|---------------------------------------|---------------|------------------------------------|------------|--|-------------|---|---------|---|
|   |                                       |               | 2024 он                            | 2025 он    | 2024 он                                      | 2025 он     | 2024 он                                   | 2025 он |   |
| 1 | Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )       | 50            | 8 мкг/м³                           | 6 мкг/м³   | 31 мкг/м³                                    | 32 мкг/м³   | 0 %                                       | 0 %     | АЧС-аас давсан тохиолдол байхгүй  |
| 2 | Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) | 50            | 37 мкг/м³                          | 21 мкг/м³  | 172 мкг/м³                                   | 56 мкг/м³   | 9 %                                       | 1 %     | Баруун 4-н зам орчим АЧС-аас 1.1 дахин их   |
| 3 | PM10 Тоосонцор                        | 100           | 71 мкг/м³                          | 46 мкг/м³  | 205 мкг/м³                                   | 143 мкг/м³  | 14 %                                      | 5 %     | Баруун 4-н зам орчим АЧС-аас 1.4 дахин их   |
| 4 | PM2.5 Тоосонцор                       | 37.5          | 11 мкг/м³                          | 8 мкг/м³   | 54 мкг/м³                                    | 21 мкг/м³   | 1 %                                       | 0 %     | АЧС-аас давсан тохиолдол байхгүй  |
| 5 | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)        | 4000          | 482 мкг/м³                         | 379 мкг/м³ | 4102 мкг/м³                                  | 2027 мкг/м³ | 1 %                                       | 0 %     | АЧС-аас давсан тохиолдол байхгүй  |
| 6 | Озон (O <sub>3</sub> )                | 100           | 40 мкг/м³                          | 33 мкг/м³  | 122 мкг/м³                                   | 105 мкг/м³  | 2 %                                       | 1 %     | Толгойт орчим АЧС-аас 1 дахин их  |

Улаанбаатар хотын өнгөрсөн 7 хоногийн цаг агаар, 2025 оны 09 дугаар сарын 01-07-ны өдөр /2024 оны мөн үетэй харьцуулснаар/

| № | Цаг агаарын үзүүлэлт     | 2024 он | 2025 он | Тайлбар                 |
|---|--------------------------|---------|---------|-------------------------|
| 1 | Дундаж температур, °C    | 14.7 °C | 12.2 °C | 2.5°C-аар бага          |
| 2 | Салхины дундаж хурд, м/с | 2.2 м/с | 2.8 м/с | 0.6 м/с-ээр их салхитай |
| 3 | Хур тунадасны хэмжээ, мм | 0.0 мм  | 1.8 мм  | 1.8 мм хур тунадастай   |

“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл

Улаанбаатар хотын агаарын чанарын индексийн мэдээ /2024 оны 09 дугаар сарын 02-08-ны өдөр/

| №  |                      | 2025.09.01 | 2025.09.02 | 2025.09.03      | 2025.09.04      | 2025.09.05 | 2025.09.06 | 2025.09.07 |
|----|----------------------|------------|------------|-----------------|-----------------|------------|------------|------------|
| 1  | 1-р хороолол         |            |            |                 |                 |            |            |            |
| 2  | 100-н айл            |            |            |                 |                 |            |            |            |
| 3  | Толгойт              |            |            |                 |                 |            |            |            |
| 4  | Нисэх                |            |            |                 |                 |            |            |            |
| 5  | Зурагт               |            |            |                 |                 |            |            |            |
| 6  | Дамбадаржаа          |            |            |                 |                 |            |            |            |
| 7  | Баянхошуу            |            |            |                 |                 |            |            |            |
| 8  | Хайлааст             |            |            |                 |                 |            |            |            |
| 9  | 5-н буудал           |            |            |                 |                 |            |            |            |
| 10 | Шархад               |            |            |                 |                 |            |            |            |
| 11 | Налайх               |            |            |                 |                 |            |            |            |
| 12 | 13-р хороолол        |            |            |                 |                 |            |            |            |
| 13 | Баруун 4-н зам       | PM10       | PM10       | NO <sub>2</sub> | NO <sub>2</sub> | PM10       | PM10       |            |
| 14 | Амгалан              |            |            |                 |                 |            |            |            |
| 15 | Цахилгаан станц      | PM10       | PM10       | PM10            | PM10            | PM10       | PM10       |            |
| 16 | Мишээл экспо         |            |            |                 |                 |            |            |            |
| 17 | Зайсан               |            |            |                 |                 |            |            |            |
| 18 | Ургах наран хороолол |            |            |                 |                 |            |            |            |
| 19 | Яармаг               | PM10       |            | PM10            |                 |            |            |            |

| Агаарын чанарын индекс | Агаарын чанарын ангилал | Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл  |
|------------------------|-------------------------|--|
| 0 - 50                 | Цэвэр                   | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй.   |
| 51-100                 | Хэвийн                  | Агаарын чанарын стандартын шаардлага хангана. Гэхдээ зарим хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.                                      |
| 101 – 200              | Бага бохирдолтой        | Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө. |
| 201 – 300              | Бохирдолтой             | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.   |
| 301- 400               | Их бохирдолтой          | Удаан хугацаагаар гадаа байхад хүний эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлж болно.   |
| 401-500                | Маш их бохирдолтой      | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.   |

Улаанбаатар хотын агаарын чанарын индексийн мэдээгээр 2025 оны 09 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд 1-р хороолол, 100-н айл, Толгойт, Зурагт, Баянхошуу, Хайлааст, 5 буудал, Шархад, Налайх, 13-р хороолол, Мишээл экспо, Зайсан орчим цэвэр болон хэвийн, Яармаг, Баруун 4 зам орчим бага бохирдолтой, харин Цахилгаан станц орчим “Бохирдолтой түвшинд хүрсэн байна.

**ШМЭХ-ийн химийн лабораториуд, химийн бодисын агуулахад хийлгэсэн агаарын шинжилгээний хэмжилтийн дүн**

“ШМЭХ” ХХК нь өөрийн салбар сургуулийн лабораториуд болон химийн бодисын агуулахад агаарын шинжилгээг ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжил зүйн төвөөр хийлгэсэн. Химийн сургалт, туршилт явуулж буй лабораториудын дотоод орчинд шинжилгээ хийлгэхэд MNS 6768:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнээс шинжлүүлсэн үзүүлэлтүүд нь хэтрээгүй байна. Шинжилгээний дүнгүүдийг хавсралтаар оруулав.

**Хүснэгт 3. Химийн лабораториуд болон агуулахад хийсэн хэмжилтийн үр дүн**

| №   | Сорьц авсан цэг                               | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup> | Азотын давхар исэл мг/м <sup>3</sup> | Нийт тоосны агууламж /TSP/, мг/м <sup>3</sup> | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|------------------|-----------------|--------------------------------|--------------------------------------|---|-----------------|
| 1   | 902-р танхим химийн инженерчлэлийн лаборатори | 25/11/03         | 15:00           | 13                             | 18                                   | 30  | 57              |
| 2   | 502-р танхим химийн лаборатори                | 25/11/03         | 15:27           | 6                              | 37                                   | 39  | 58              |
| 3.  | 216 тоот химийн лаборатори                    | 25/11/03         | 15:57           | 8                              | 30                                   | 36  | 55              |
| 4.  | В-03 тоот химийн бодисын агуулах дотор        | 25/11/03         | 16:25           | 10                             | 47                                   | 55  | 50              |
| <b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023</b>            |   |                  |                 | <b>2000</b>                    | <b>2000</b>                          | <b>10000</b>                                  | <b>-</b>        |
| <b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019</b> |   |                  |                 |                                |                                      |   | <b>85</b>       |

## ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН ХӨРСӨН БҮРХЭВЧ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Улаанбаатар хот орчмын хөрс нь хөрс-газар зүйн мужлалтаараа Хангайн их муж, Хэнтийн мужийн Хэнтийн захын хэсгийн тойрогт хамрагдах бөгөөд уулын ба хээрийн хар хүрэн, сайргархаг хар хүрэн хэв шинжит хөрс зонхилон тархана.



Зураг 12. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч, төрлөөр

Эдгээр хөрс нь уулархаг хэсэгтээ элюви ба элюви-делювийн хурдас, тэдгээрийн бэл хормойгоор делюви ба элювийн, голын сав хөндийгөөр аллювийн хурдсууд дээр тогтжээ. Элюви, делюви, элюви-делювийн хурдас нь голдуу дунд ба хөнгөн шавранцар, элсэнцэр ширхэгийн бүрэлдэхүүнтэй байхад, аллювийн хурдас нь дунд ба хүнд шавранцараас шаварлаг бүрэлдэхүүнтэй байна. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч ерөнхийдөө элэгдэл эвдрэлд орсон, ургамалан бүрхэвч талхагдсан, хог хаягдал их хэмжээгээр хуримтагдсан байдал ажиглагдаж байна. Улаанбаатар хотод хөнгөн үйлдвэрлэл болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл төвлөрсөн, бага оврын уурын зуух ба ердийн галлагаат зуух, автомашины тоо эрс нэмэгдэж байгаа зэрэг нь хотын хөрсний бохирдлын голлох эх үүсвэр болж байна. Улаанбаатар хотын бүсэд тархсан хөрсүүд багавтар ялзмагтай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй байдаг тул бохирдуулагч бодисууд хөрсний өнгөн давхаргаас доош шилжих латерал хөдөлгөөн эрчимтэй байх ба энэ нь Туул ба жижиг голуудын хөндийн хөрс, хурдсанд илүүтэй хурдацтай байна. Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч маш хүчтэй элэгдэл эвдрэлд орсон, ургамалан бүрхэвч талхагдсан, хог хаягдал их хэмжээгээр хуримтагдсан байдал ажиглагдаж байна. Ихэнх газруудад хөрсөн бүрхэвч үндсэндээ алга болж эх чулуулаг ил гарсан байна. Улаанбаатар хотод хөнгөн болон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл төвлөрсөн, бага оврын уурын зуух ба ердийн галлагаат зуух, автомашины тоо эрс нэмэгдэж байгаа зэрэг нь хотын хөрсний бохирдлын голлох эх үүсвэр болж байна. Хотын цахилгаан станцууд, аж үйлдвэрийн томоохон үйлдвэрүүд, тэдэнтэй холбогдсон бохир ба хаягдал усны сурвалжууд, хог хаягдлын төв цэгүүд нь хот орчмын салхины голлох чиглэлийн эхэн болох баруун, баруун хойт, хойт хэсэгт байрласан байдаг

“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл

учраас хотын баруун, төв ба хойд хэсэг, дархан цаазат Богд уулын ар хажуугийн экосистемд сөрөг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлдэг. Улаанбаатар хотын бүсэд тархсан хөрсүүд багавтар ялзмагтай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй байдаг тул бохирдуулагч бодисууд хөрсний өнгөн давхаргаас доош шилжих латерал хөдөлгөөн эрчимтэй байх ба энэ нь Туул ба жижиг голуудын хөндийн хөрс, хурдсанд илүүтэй хурдацтай. Улаанбаатар хотын хөрс-литогеохимийн ерөнхий бохирдолтын түвшин Улаанчулуут, Дарь-эхийн хогийн цэг, Хотын цэвэрлэх байгууламж, Нарантуул зах, Шархадны автомашины зах, III-IV цахилгаан станц, Дэнжийн мянга, Хайлаастын ам, Шарга морьтын зуслангийн адаг, 100 айл орчим зэрэг газруудад онцгой их буюу хотын дундаж агууламжаас 10-16 дахин их байж, “хэт их бохирдолттой” зэрэглэлд багтана. Хотын төв хэсэг, гэр хороолол, баруун талын дүүргийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ хотын дундаж дэсвгэр агууламжаас 3-8 дахин ( $Z_c = 3.0 - 8.0$ ) их буюу “бохирдолттой” гэсэн зэрэглэлд багтаж байна.

### Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжиж төлөвлөж буй газар нь далайн түвшинээс дээш 1280 метр өргөгдсөн, тэгш талбайд байрлах ба талбайн ихэнхи хэсэг нь цементлэгдсэн байна. Хөрсний аргахимийн үзүүлэлт болон хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор төсөл хэрэгжиж буй талбайн хөрсөн бүрхэвч бүхий хэсгээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн болно.

### Хөрсний морфологи шинж чанар

**(Ердийн хүрэн хөрс):** Энэ хөрсний гадарга дээр сайр чулууны бүрхэц 0-5%, ургамал бүрхэц 10-20%, хүний нөлөөтэй эвдрэл талхагдал харьцангуй бага, бохирдол байхгүй, газрын гадарга нь тэгш гадаргатай байна.

**“А” 0-10 см.** Бор шаргал өнгөтэй, ургамлын үндэсээр элбэг, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, нягтавтар, шилжилт өнгөөр аажим

**“В” 10-22 см.** Хуурай, бор цайвар өнгөтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, ургамлын үндэстэй, сийрэгдүү нягтшилтай



### Хөрсний агро-хими, физик шинж чанар

#### Хөрсний урвалын орчин (pH)

Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний pH-ийн утга 8.38 буюу сул шүлтлэг урвалын орчинтой байна.

Хүснэгт 4. Хөрсний агрохими шинж чанар

| Дээжний дугаар | Гүн, см | pH   | CaCO <sub>3</sub> % | Ялзмаг % | ЕС <sub>2.5</sub> dS/m | Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр |     | Хөдөлгөөнт, мг/100г           |                  |
|----------------|---------|------|---------------------|----------|------------------------|------------------------------------|-----|-------------------------------|------------------|
|                |         |      |                     |          |                        | Ca                                 | Mg  | P <sub>2</sub> O <sub>5</sub> | K <sub>2</sub> O |
| 1              | 0-20    | 8.38 | 0.66                | 3.31     | 0.07                   | 21.1                               | 1.2 | 2.4                           | 4.7              |

**Хөрсний карбонат**

Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO<sub>3</sub>)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Хөрсөнд янз бүрийн анхдагч болон хоёрдогч карбонатууд байдаг. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний карбонатын утгын хэлбэлзэл 0.66% буюу сул карбонатжилттай байна.

**Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС 1:2.5) буюу хялбар уусах давсжилт**

ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг ЕС-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад ЕС-ийн утга 0.07 dS/m сул давсжилтгүй байна.

**Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O)**

Хөрсний азот, фосфор, кали (N,P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Азот (N) нь ургамлын өсөлтийн олон процесст чухал үүрэгтэй байдаг. Тухайлбал, азот нь фотосинтезийн үйл явцад амин чухал нөлөөтэй юм. Харин Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P<sub>2</sub>O<sub>5</sub>) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидаг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K<sub>2</sub>O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K<sub>2</sub>O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад өнгөн үеийн P<sub>2</sub>O<sub>5</sub>-ын утга 2.4 мг/100г -ийн сайн хангамжтай байна. Хөдөлгөөнт калийн хувьд өнгөн үеийн утга 4.7 мг/100г -ийн бага хангамжтай байна.

**Хөрсний механик (ширхэгийн) бүрэлдэхүүн**

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн

хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхэгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаварных <0.002мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэд маш нөлөөтэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг. Харин шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс элсэнцрээс эсрэгээр байдаг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсөн дэх тоос болон элсэн фракцын эзлэх хувь их буюу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 5. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн

| Дээжний дугаар | Гүн, см | Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр) |           |           |            |             |        |       | Механик бүрэлдэхүүн |
|----------------|---------|------------------------------|-----------|-----------|------------|-------------|--------|-------|---------------------|
|                |         | 2,0-0.26                     | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |                     |
| 1              | 0-20    | 13.6                         | 42.5      | 22.4      | 9.6        | 7.8         | 4.1    | 21.5  | Элсэнцэр            |

### Хөрсний бохирдлын түвшин

Хөрсөнд хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, янз бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болдог 12 хүнд металл байдаг. Эдгээрийг дотор нь онцгой хортой (As, Cd, Cr, Pb) болон био-идэвхт (Cu, Co, Mo, Ni, Sr, V, Zn) гэж ангилдаг. Судалгааны үр дүнгээс харахад дээрх металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн бөгөөд бүгд стандартын дээд хэмжээнээс хэтрээгүй хэвийн түвшинд байна.

Хүснэгт 6. Хөрсний хүнд металлын агууламж

| Дээжний дугаар   | Хөрсний төлөв     | Агууламж, мг/кг      |              |             |             |              |              |
|--|-------------------|----------------------|--------------|-------------|-------------|--------------|--------------|
|  |                   | Cd                   | Cr           | Pb          | Cu          | Ni           | Zn           |
| 1  | Ердийн хүрэн хөрс | -                    | 13.5         | 26.9        | 31.1        | 14.4         | 54.1         |
| <b>Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ</b>      |                   | <b>1.5</b>           | <b>100.0</b> | <b>70.0</b> | <b>80.0</b> | <b>100.0</b> | <b>150.0</b> |
| <b>Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ</b>       |                   | <b>1.0</b>           | <b>60.0</b>  | <b>50.0</b> | <b>60.0</b> | <b>60.0</b>  | <b>100.0</b> |
| <b>Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт</b> |                   | <b>MNS 5850:2019</b> |              |             |             |              |              |

### 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


| №   | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Төлөвлөгөөний биелэлт   | Нийт дүн, мян.төг | Баримтлах эрхзүйн баримт бичиг   |
|---|--------------------------------------|--|---|-------------------|--|
|   | 1                                    | 2  | 3   | 4                 | 5  |
| <b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар</b> |                                      |  |   |                   |  |
| 1.  | Агаарт химийн бодис тархах           | Химийн бодисын лабораториуд болон химийн бодисын агуулахын дотоод агааржуулалтын системийн ажиллагаанд байнга хяналт тавих | <p>Бүх лабораториуд нь автомат агаажуулалтын системтэй бөгөөд үйл ажиллагааны явцад агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг шалгаж, хяналт тавьж ажиллаж байна.</p>   <p>Мөн лабораториудад агаарын чанарын үндсэн үзүүлэлтүүд болох азотын давхар исэл-<math>\text{NO}_2</math> мкг/м<sup>3</sup>, хүхэрлэг хий <math>\text{SO}_2</math> мкг/м<sup>3</sup>, нийт тоос мкг/м<sup>3</sup> зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж орчны бохирдлыг хянаж ажиллаж байна.</p> | 300.0             | <p>MNS 4585:2025<br/>Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага<br/>MNS 4990:2023</p> |



Агаарын дээж авч байх үеийн фото

**Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар**

Хөдөлмөрийн аюулгүй  
байдал, эрүүл мэнд.  
Шуугианы норм. Аюулгүй  
ажиллагааны ерөнхий  
шаардлага MNS 6768:2019

|           |   |  |   |                                |  |
|-----------|---|--|---|--------------------------------|--|
| <p>2.</p> | <p>Ахуйн болон хатуу хог хаягдлаар хөрс бохирдох</p>  | <p>Бүх төрлийн хатуу болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал түр хадгалах саванд байнга хяналт тавих</p> | <p>Ахуйн хог хаягдлыг БЗД-н Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-тай хийсэн гэрээний дагуу зайлуулдаг бөгөөд ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухай бүрд нь хийж ажиллаж байна.</p>                         | <p>Гэрээний дагуу хийгддэг</p> | <p>Хог хаягдлын тухай хууль /2017 он/,<br/>Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль MNS 5850:2019.<br/>“Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”</p> |
| <p>3.</p> | <p>Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим, сургалт туршилтад ашиглах үед болгоомжгүй байдлаас химийн бодис алдагдсан тохиолдолд</p> | <p>Химийн бодис урвалжийг алдагдахаас сэргийлж байнга анхаарал сэрэмжтэй ажиллах</p>                                 | <p>Химийн бодисыг зөвхөн сургалт, туршилтын зориулалтаар ашигладаг бөгөөд сургалт явуулж буй сургалтын лабораториуд нь хөдөлмөр хамгааллын нөхцөл аюулгүй ажиллагааг бүрэн хангасан. Химийн бодистой харьцдаг багш, лаборантууд, оюутан, сурагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг сайтар танилцуулж гарын үсэг зуруулсны дараа сорил</p> | <p>350.0</p>                   | <p>Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль, MNS 5850:2019.<br/>“Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”</p>  |

|   |  |   |  |   |   |
|---|--|---|--|---|---|
| хөрс бохирдож болзошгүй   |  | туршилтын хичээлийг эхлүүлдэг.  |  |   |   |
|  |  |  |  |  |  |
| Хамгаалалтын хувцас хэрэглэл  |  |   |  | Анхны тусламжийн хэрэглэл   | Ариутгал, химийн бодистой ажиллах үед ашигладаг хувцас хэрэгсэл                     |
| <b>Биелэлт</b>  |  |   |  | <b>100%</b>   | <b>650.0</b> -  |

## 2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тарих, мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд “Шинэ Монгол Эрдмийн Хүрээлэн” ХХК нь “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-тай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 30 шихрэг гацуур тарьж ургуулж байна.

| Д.д   | Гол ба болзошгүй сөрөг нөлөө  | Төлөвлөгөөний биелэлт   |
|---|---|---|
| 1.  | Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэр бум мод үндэсний хөдөлгөөн болон “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-тай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу мод бут тарьж ургуулах | Тэр бум мод үндэсний хөдөлгөөн болон “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-тай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу ШМЭХ-ийн багш, сурагчид Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 30 шихрэг гацуур тарьж ургуулж байна. |
|  |   |   |
| Нийт дүн, мян.төг   |   | 1000.0  |
| Биелэлт   |   | 100%  |

### **3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртсөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлын тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө хийх шаардлагагүй тул биелэлтийг тайлагнаагүй болно.

### **4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тухайн төслийн үйлчилгээ болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

### **5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

## 6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө   | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ   | Төлөвлөгөөний биелэлт  | Баримтлах стандарт, аргачлал   |
|--|--|--|--|
| Цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах             | Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, аюулын гарцын байрлалыг заасан самбар хадах, галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх | Сургуулийн барилга болон химийн лабораториуд, химийн бодисын агуулах зэрэгт галын аюулгүй байдлыг хамгаалах багаж хэрэгсэлийг зохих газарт нь байрлуулсан бөгөөд ашиглалтын хугацаанд байнга хяналт тавьж ажиллаж байна.           | Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 27-1<br><br>MNS 4990:2023<br>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага |
|  |  |  |  |
| Галын аюулгүй байдлын самбар, гал унтраах багаж хэрэгсэл                           |  | Аюулын үед гарах гарцны схем зураг, галын гидранд, элс зэргийг байрлуулсан байдал  |  |
| Химийн бодис алдагдсанаас ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх               | Ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт орсон байх   | Сургуулийн удирдлагын зүгээс химийн бодистой харьцан ажилладаг багш ажилчдыг жил бүр хавдар судлалын үндэсний төв болон АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгийн хамтран ажиллах гэрээний дагуу эмчийн үзлэг шинжилгээнд хамруулж байна. |  |



Анхны тусламжийн хайрцаг, нүд угаах шингэн, хамгаалалтын хувцас хэрэгсэл

Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцастай байх /гутал, резинэн бээлий, хамгаалалтын хошуувч/




Хамгаалалтын хувцас хэрэгсэл

Ажиллагсадыг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах

ШМЭХ-н удирдлагын зүгээс багш, ажилчдыг үе шаттайгаар химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулдаг.



“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл



Нийслэлийн боловсролын газраас зохион байгуулсан химийн лабораторийн менежмент, аюулгүй ажиллагааны сургалтанд сууж байгаа байдал

Биелэлт


100%

**7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Болзошгүй сөрөг нөлөөлөл  | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ   | Нийт дүн, мян.төг   | Төлөвлөгөөний биелэлт   | Баримтлах эрх зүйн баримт бичиг                                 |
|---|--|---|---|---|
| <p>Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, төслийн орчинд бохирдол үүсгэж болзошгүй</p> | <p>Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх</p>                                | <p>350.0</p>  | <p>Лаборатори болон химийн бодисын хадгалах өрөөний ариутгал цэвэрлэгээг зориулалтын хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж байна</p>   | <p>Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд</p> |
|   | <p>Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх</p> | <p>Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-тай хийсэн гэрээний дагуу тооцогддог</p> | <p>Ахуйн хог хаягдлыг БЗД-н Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-тай хийсэн гэрээний дагуу зайлуулдаг бөгөөд ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухай бүрд нь хийж ажиллаж байна.</p>    |   |

|                          |  |                |  |   |
|--------------------------|--|----------------|--|---|
|                          | Химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдал зайлуулах гэрээний дагуу зохицуулах | Гэрээний дагуу | Харин аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-тай хийсэн гэрээний дагуу хүлээлгэн өгдөг |  |
| <b>Нийт дүн, мян.төг</b> | <b>300.0</b>   | <b>Биелэлт</b> | <b>100%</b>  |   |

### 8. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| Байгаль орчны бүрэлдэхүүн | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт  | Хэмжих нэгж       | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ          | Нэгжийн өртөг мян.төг | Биелэлт  | Баримтлах стандарт ба арга аргачлал  |
|---------------------------|---|-------------------|--------------------|---|-----------------------|--|--|
| Агаар                     | SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , TSP   | мг/м <sup>3</sup> | Жилд 1 удаа        | Лабораториуд болон агуулахын дотоод орчин | 200.0                 | <p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ШМЭХ-ийн лаборатори болон химийн бодисын агуулахын өрөөний агаарын шинжилгээг ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжил зүйн төвөөр хийлгэсэн.</p>  | <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019</p> |
| Хөрс                      | <p>Ялзмаг<br/>Урвалын орчин-рН<br/>Карбонат<br/>Хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K2O)<br/>Цахилгаан дамжуулах чанар</p> <p>Механик бүрэлдэхүүн Чулуу</p> <p>Хүнд металлууд Pb,Co,Ni,Cr,Cd</p> | мг                | Жилд 1 удаа        | Ил хөрстэй хэсгээс                        | 144.0                 | <p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжиж буй газрын ил хөрстэй хэсгээс дээж авч “Ланд овнер” ХХК-ний лабораторид шинжлүүлсэн.</p>                                 | <p>Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850-2019 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990</p>                         |
| <b>Нийт</b>               |   |                   |                    |   | <b>344.0</b>          |  | -  |

**9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| №              | Хийгдэх ажлын нэр төрөл   | Хийгдэх шаардлага  | Хийх хугацаа                          | Биелэлт  |
|----------------|---|--|---------------------------------------|--|
